



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/95НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягуур олоно уу.



Аудитын холбогдуувар газрын захирал, төргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосожаргал
Утас: 261685 Цахим хаяг: khosjargal@audit.gov.mn
Аудитор: С.Бал-Эрдэнэ
Утас: 260513 Цахим хаяг: bal-erdene@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Мүүрч аудит ХХК-ийн
МТХ Захирал: У.Оюунваа
Утас: 70150903 Цахим хаяг: info@moore-mongolia.mn

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
4.1 Байгууллагын үйл ажилагаа	12
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
5.1 Шилэн дансны мэдээлэл	16
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
8. Аудитын илрүүлэлт	18
8.1 Залруулсан алдаа	18
8.2 Төлбөрийн акт	19
8.3 Албан шаардлага	19
8.4 Зөвлөмж	20
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХХО	Богино Хугацаат Хөрөнгө Оруулалт
ДҮТ ТӨХХК	Диспетчерийн Үндэсний Төв Төрийн Өмчит Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ДЭХ	Дулааны Эрчим Хүч
ЗГ	Засгийн Газар
НББ	Нягтлан Бодох Бүртгэл
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨ	Төрийн Болон Орон Нутгийн Өмч
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат Компани
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ХЧТА	Хөдөлмөрийн Чадвар Түр Алдалт
ЦЭХ	Цахилгаан Эрчим Хүч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 071602

танай _____ -ны № _____ -т

ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ү.ТӨМӨРХУЯГ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч компаниас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.


Асуудлыг онцолсон зүйл

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь Хөгжлийн Турбоагрегат 1,2,3,4-ийн шинэчлэлтэй холбоотойгоор 76.6 сая евро буюу 234,605.5 сая төгрөгийн зээл авсан байна. Урт хугацаат зээлийн эргэн төлөлт 11.4 сая евро буюу 30,180.4 сая төгрөг, зээлийн үлдэгдэл 75.1 сая евро буюу 241,907.9 сая төгрөг байна. 2021 онд төлөгдөх үндсэн зээл болон хүүгийн төлбөрөөс хугацаандаа төлөгдөөгүй үндсэн зээлийн төлбөр 7.3 сая евро буюу 23,502.1 сая төгрөг, хүүгийн төлбөр 1.7 сая евро буюу 5,540.6 сая төгрөг байна.

Хөгжлийн банкны зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос 2022 оны сүүлийн хагас жилд үнэ тарифт өөрчлөлт оруулж, зээлийн төлбөр төлөх эх үүсвэрийг шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.



Эрчим хүчний сайдын 2021 оны 9 дүгээр тушаалаар 2021 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 280,782.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 297,369.8 сая төгрөгөөр, алдагдлыг 16,587.1 сая төгрөг байхаар баталсан байна. Эрчим хүчний сайдын 2021 оны 196 дугаар тушаалаар их завсар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 935.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 348,222.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 329,207.7 сая төгрөгийн зардал гарган, 17,829.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 93 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,778,942,276.43	9,045,731,174.07
1.1.2	Дансны авлага	17,045,970,280.56	31,334,225,715.66
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	812,834,808.53	469,889,846.23
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	19,990,657,260.01	19,376,776,761.65
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,905,175,418.73	1,649,758,280.72
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	45,533,580,044.26	61,876,381,778.33
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	895,473,181,544.62	912,358,875,809.05
1.2.2	Биет бус хөрөнгө	76,973,695,336.34	76,925,722,242.26
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	40,075,045,153.34	105,136,899.92
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,012,521,922,034.30	989,389,734,951.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,058,055,502,078.56	1,051,266,116,729.56
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	10,474,997,095.38	8,650,577,597.79
2.1.1.2	Цалингийн өглөг	5,623,480,582.72	5,964,378,732.01
2.1.1.3	Татварын өр	6,248,371,787.51	1,355,387,449.54
2.1.1.4	НДШ – ийн өглөг	1,221,257,633.86	945,000,000.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	34,626,216,866.47	74,597,989,845.30
2.1.1.6	Хүүгийн өглөг	3,228,876,329.88	7,080,411,925.72
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	5,098,331,837.08	942,139,358.69
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	1,968,227,800.95	1,606,419,976.94
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	3,698,433,839.98	1,169,675,884.30
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	72,188,193,773.83	102,311,980,770.29
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	385,163,163,701.51	325,797,067,292.37
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	8,520,087,760.40	9,318,690,994.43
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	13,363,759,906.17	13,933,080,225.28
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5	Хойшлогдсон орлого	111,160,337,263.84	18,877,481,320.45
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	518,207,348,631.92	367,926,319,832.63



2.2	Өр төлбөрийн нийт дүн	590,395,542,405.75	470,238,300,602.82
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-төрийн	107,919,748,900.04	227,071,740,030.34
2.3.2	хувийн	-	-
2.3.3	хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	312,961,105,414.66	311,515,695,204.19
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	78,008,219,977.00	78,008,219,977.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(31,229,114,618.89)	(35,567,839,084.79)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	467,659,959,672.81	581,027,816,126.74
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,058,055,502,078.56	1,051,266,116,729.56

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	286,659,965,056.65	311,499,629,903.73
2	Борлуулалтын өртөг	285,822,703,198.19	313,256,103,399.91
3	Нийт ашиг(алдагдал)	837,261,858.46	(1,756,473,496.18)
4	Түрээсийн орлого	173,463,700.00	180,717,356.62
5	Хүний орлого	111,345,709.80	2,733,639.77
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	8,621,000,560.28	4,117,760,939.02
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,607,454,542.07	2,140,421,864.94
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,121,752,446.91	4,827,102,800.71
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	2,426,033,005.11	4,485,336,645.01
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(35,878,706,061.68)	32,415,627,392.97
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(4,493,011,984.90)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	10,272,727.29	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(34,280,601,499.94)	19,014,492,536.64
19	Орлогын татварын зардал	1,207,284,096.39	1,184,714,132.19
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(35,487,885,596.33)	17,829,778,404.45
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(35,487,885,596.33)	17,829,778,404.45

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	107,919,748,900.04	312,961,118,390.38	48,769,166,973.00	6,776,980,807.71	476,427,015,071.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	0.04	-	(2,430,201,538.93)	(2,430,201,538.89)
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(35,487,885,596.33)	(35,487,885,596.33)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(88,008,291.34)	(88,008,291.34)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(12,975.76)	29,239,053,004.00	-	29,239,040,028.24
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	107,919,748,900.04	312,961,105,414.66	78,008,219,977.00	(31,229,114,618.89)	467,659,959,672.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(22,168,502,870.35)	(22,168,502,870.35)
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	17,829,778,404.45	17,829,778,404.45
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	119,151,991,130.30	-	-	-	119,151,991,130.30
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(1,445,410,210.47)	-	-	(1,445,410,210.47)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	227,071,740,030.34	311,515,695,204.19	78,008,219,977.00	(35,567,839,084.79)	581,027,816,126.74

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	276,267,138,039.67	284,408,100,391.64
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	270,650,498,339.94	277,827,302,009.92
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	5,616,639,699.73	6,580,798,381.72
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	255,349,594,075.29	270,604,336,273.50
	Ажиллагчдад төлсөн	39,268,229,519.33	37,346,046,230.21
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	10,465,000,000.00	13,113,865,781.16
	Бараа материал худалдан авахад төлсөн	118,296,717,183.00	131,115,200,000.00
	Ашиглалтын зардалд төлсөн	-	-
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	41,895,017,771.95	34,900,738,631.08
	Хүүгийн төлбөрт төлсөн	8,276,881,856.33	6,779,096,613.45
	Татварын байгууллагад төлсөн	21,446,112,301.13	20,278,275,595.68
	Даатгалын төлбөрт төлсөн	77,600,083.15	78,798,026.00
	Бусад мөнгөн зарлага	15,624,035,360.40	26,992,315,395.92
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	20,917,543,964.38	13,803,764,118.14
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	111,345,709.80	2,733,639.77
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүгийн орлого	111,345,709.80	2,733,639.77
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	60,716,733,454.40	25,741,573,568.49
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,931,929,177.00	4,440,112,448.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	51,784,804,277.40	21,301,461,120.49
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(60,605,387,744.60)	(25,738,839,928.72)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	56,784,804,277.40	28,300,157,046.86
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	56,784,804,277.40	28,300,157,046.86

	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,910,474,177.21	10,098,292,338.64
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	14,910,474,177.21	10,098,292,338.64
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	41,874,330,100.19	18,201,864,708.22
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,186,486,319.97	6,266,788,897.64
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	592,455,956.46	2,778,942,276.43
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,778,942,276.43	9,045,731,174.07

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Боловсруулсан	ЦЭХ	Сая кВтц	4,110.3	4,102.5	4,538.7	436.2	110.6
		ДЭХ	Мян.Гкал	4,029.5	4,205.2	4,172.1	(33.1)	99.2
	Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний зарцуулалт	Хувиар	Хувь	11.7	11.8	11.2	(0.6)	94.9
		Биетээр	Сая.кВт.ц	482.5	484.3	509.7	25.4	105.2
	Эрчим хүч түгээлт	ЦЭХ	Сая кВтц	3,627.8	3,618.2	4,028.9	410.7	111.4
ДЭХ		Мян.Гкал	4,029.5	4,205.2	4,172.1	(33.1)	99.2	
2	Нийт орлого		Сая.төг	295,923.4	280,782.6	348,222.2	67,439.6	24.0
	Үүнээс: Борлуулалтын орлого		Сая.төг	286,660.0	276,699.2	311,499.6	34,800.4	12.6
	Үйл ажиллагааны бус орлого		Сая.төг	8,916.1	4,083.5	36,722.6	32,639.1	799.3
3	Нийт зардал		Сая.төг	329,856.6	297,369.8	329,207.7	31,837.9	10.7
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал		Сая.төг	291,555.5	293,407.6	322,578.0	29,170.4	9.9
	Үйл ажиллагааны бус зардал		Сая.төг	38,301.1	3,962.1	6,629.7	2,667.6	67.3
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		Сая.төг	(34,280.6)	(16,587.1)	19,014.5	35,601.6	214.6
5	Татварын дараах ашиг /алдагдал/		Сая.төг	(35,487.9)	(16,587.1)	17,829.8	34,416.9	207.5
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		Төгрөг	0.99	1.06	1.06	0.00	0
7	Нийт авлага		Сая.төг	17,858.8	12,630.0	31,804.1	19,174.1	151.8
	Үүнээс	ЭХ-ний	Сая.төг	17,045.9	12,215.0	31,334.2	19,119.2	256.5
		Бусад	Сая.төг	812.9	415.0	469.9	54.9	113.2
8	Нийт өглөг		Сая.төг	474,136.9	573,946.1	470,238.2	(103,707.9)	18.0
	Үүнээс	УХӨТ	Сая.төг	407,047.0	504,510.5	387,926.3	(136,584.2)	72.9
		БХӨТ	Сая.төг	67,089.9	69,435.6	102,311.9	(32,876.3)	147.3
9	Нийт ажиллагсад		Тоо	1,489	1,490	1,480	(10)	0.7
10	Нийт цалингийн сан		Сая.төг	46,848.5	46,892.8	46,845.7	(47.1)	0.1
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	Цахилгаан	Гр/кВтц	278.8	279.6	270.9	(8.7)	96.9
		Дулаан	Гр/Гкал	171.7	172.6	172.2	(0.4)	99.8
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		Сая.төг	23,448.8	26,578.8	21,115.9	(5,462.9)	20.5

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөхөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч компанид шилэн дансны мэдээлэл, нийгмийн даатгалын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 16-аас 2022 оны 03 дугаар сарын 10-ны хооронд Мүүрь аудит ХХК-ийн баталгаажуулах үйлчилгээний ахлах менежер Н.Дагийрагчаа, аудитор А.Солонго, аудитын туслах Э.Пүрэвсүрэн, П.Цагаанхүү, О.Баясгалан, Ч.Жаргалдулам нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Н.Гэрэлчимэг, мэргэжлийн үйлчилгээ хариуцсан захирал У.Оюунаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Мүүрь аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/153 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналтын албаны санхүүгийн хяналтын дотоод аудитор нь тайлант онд хийх ажлын төлөвлөгөөг 6 чиглэлд нийт 15 ажил хийхээр батлуулж, үүнээс 4 чиглэлийн 10 ажлыг 100.0 хувь, 1 чиглэлийн 1 ажлыг 80 хувь, 1 чиглэлийн 4 ажлыг 95.0 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг акрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын

дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлого 286,660.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,866.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн эрхэм зорилго нь "Эх орны хөгжлийн баталгаа, эрчим хүчний хүчирхэг тулгуур нь байна" гэж тодорхойлсон байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цахилгааны, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хангах, түгээх, худалдах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨХК статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс ТӨБЗГ 30.0 хувь, Эрчим хүчний яам 70.0 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолыг үндэслэн бие даасан төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн өөрчлөн зохион байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;..." гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг ТУЗ-ийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.8 дах заалт "Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох", ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.7 дах заалт "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох" гэсэн заалтуудтай нийцэж байна.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг сард 0.8 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн

нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон зэрэг өөрчлөлт хийгдээгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- ЗГ-ын 2021 оны 43 тоот тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай".

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дулааны IV цахилгаан тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,778,942.3	9,045,731.2	6,266,788.9
БХХО	-	-	-
Авлага	17,858,805.1	31,804,115.6	13,945,310.5
Урьдчилгаа	4,905,175.4	1,649,758.3	(3,255,417.1)
Бараа материал	19,990,657.3	19,376,776.7	(613,880.6)
Үндсэн хөрөнгө	935,548,226.7	912,464,012.7	(23,084,214.0)
Биет бус хөрөнгө	76,973,695.3	76,925,722.2	(47,973.1)
Нийт хөрөнгийн дүн	1,058,055,502.1	1,051,266,116.7	(6,789,385.4)
Богино хугацаат өглөг	72,188,193.8	102,311,980.8	30,123,787.0
Урт хугацаат өглөг	518,207,348.6	367,926,319.8	(150,281,028.8)
Эздийн өмч	467,659,959.7	581,027,816.1	113,367,856.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,058,055,502.1	1,051,266,116.7	(6,789,385.4)

Касс дахь бэлэн мөнгө 13.7 сая, банк дахь харилцах дансанд 7,861.8 сая, замд яваа мөнгө 1,170.2 сая төгрөг байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд үүссэн ДҮТ ТӨХХК-аас авах авлага 14,840.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 32,994.6 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 305.3 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлагыг нөөцийн аргаар тооцдог бөгөөд тайлант онд 147.2 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулсан байна.

Тайлант онд Od ERP системийн шинэ хувилбарыг нэвтрүүлэхтэй холбоотой ажлын төлбөрт 102.4 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 онд шилжүүлсэн 5.0 сая төгрөгийн ажил Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хийгдээгүй, 20.4 сая төгрөгийг эрчим хүчний салбарын аж ахуйн

нэгж байгууллагад хяналт шалгалт хэрэгжүүлэх гэрээний төлбөр бүртгэлтэй байгаа ба эцсийн гүйцэтгэл гараагүй шалтгаанаар дуусаагүй, гүйцэтгэлийг хүлээн аваагүй байна.

Урьдчилгаа данснаас тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 9,179.6 сая төгрөгийг зардалд хүлээн зөвшөөрсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19,376.8 сая төгрөг болж 613.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд сэлбэг хэрэгслийг урсгал болон их засварт зарцуулснаас шалтгаалжээ. Тайлант онд худалдан авалтаар 174,568.2 сая төгрөг, тооллогоор илүүдсэн 40.5 сая төгрөгийн бараа материалаар бараа материал данс нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд тэжээлийн модуль, дифференциал даралтын хэмжүүр, домбон холхивч, керамик чулуу, кольцо, резин, ремен, үрлэн холхивч, хамгаалах клапан, тохируулах клапан, цахилгаан хөдөлгүүр, шибер, эрвээхэй хаалтын редуктор, труба, шугам хоолой зэрэг 5,804.0 сая төгрөгийн бараа материалд хөдөлгөөн ороогүй байна. Энэ нь өмнөх онуудад бэлтгэсэн аваарын нөөц болон хуучин тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэлтэй холбоотой байна. Эдгээр бараа материал ашиглагдахгүй удсанаар хуучрах, эвдэрч гэмтэх, үнэ цэний бууралтад орох магадлал өндөр байна.

Оны эцэст 17,573.3 сая төгрөгийн нүүрсний худалдан авалт хийж, нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 56,864.5 сая, их засварын капиталжуулсан 26,930.8 сая, Эрчим хүчний яамнаас үнэ төлбөргүй хүлээн авсан 750.8 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 122, 385, 370 дугаар тогтоолоор худалдан борлуулсан 671.6 сая, 2021 оны 349, 1149 дүгээр тогтоолоор акталсан 15,118.3 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 45.4 сая төгрөгийн программ хангамжийн хөгжүүлэлтийн дүнгээр нэмэгджээ.

Бусад эргэлтийн бус хөрөнгө 39,969.9 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлсэн дүнгээр буурчээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд худалдааны өглөг 8,650.6 сая төгрөг, цалингийн өглөг 5,964.4 сая төгрөг, зээлийн хүүгийн өглөг 7,080.4 сая төгрөг, татвар, НДШ-ийн өглөг 945.0 сая төгрөг, богино хугацаат зээл 74,598.0 сая төгрөг, урьдчилж орсон орлого 942.1 сая төгрөг, нөөц өр төлбөр 1,606.4 сая төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 1,169.7 сая төгрөгийн өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 1998-2021 онуудад Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Сангийн яам, Хөгжлийн банкнаас Турбоагрегат 1,2,3,4-ийг шинэчлэх, дулааны үр ашгийг дээшлүүлэх, эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр болон "Дулааны IV цахилгаан станц" ТӨХК-ийн хүчин чадлыг 123 Мвт-аар нэмэгдүүлэх чиглэлээр 11 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байгаатай холбоотой авсан нийт 426,802.6 сая төгрөгийн зээлээс 101,005.6 сая төгрөг төлөгдсөн, үлдэгдэл 325,797.0 сая төгрөгийн зээл байна. Урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийн дутагдалд орсноос шалтгаалсан, төлбөрийн чадвар буурч, санхүүгийн хүндрэлд орж болзошгүй үр дагавартай байна. Урт хугацаат өр төлбөрийн үлдсэн хэсэгт 9,318.7 сая төгрөгийн тэтгэврийн нөөц өр төлбөр, 13,933.1 сая төгрөгийн хойшлогдсон татварын өр төлбөр, улсын төсвийн санхүүжилтээр баригдсан хөрөнгөтэй холбоотойгоор үүссэн 18,877.5 сая төгрөгийн хойшлогдсон орлого байна.

Компани Хөгжлийн банкнаас 2018-2021 онуудад нийт 76.6 сая евро буюу 234,605.5 сая төгрөгийн зээлийг Турбоагрегат 1,2,3,4-ийг шинэчлэх, 2015 онд 9.8 сая ам.доллар буюу 19,481.0 сая төгрөгийн зээлийг "Дулааны IV цахилгаан станц" ТӨХК-ийн хүчин чадлыг

123Мвт-аар нэмэгдүүлэх зориулалттай авч, зээлийг зориулалтын дагуу Турбоагрегат 1,2,3,4-ийг шинэчлэх болон станцын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд зарцуулжээ.

Тайлант онд "Дулааны IV цахилгаан станц" ТӨХК-ийн хүчин чадлыг 123Мвт-аар нэмэгдүүлэх зориулалтаар Хөгжлийн банкнаас авсан ам.долларын зээлийн үлдэгдэл 1.6 сая ам.доллар буюу 4,598.6 сая төгрөгийг төлж уг зээлийг хаасан байна.

Еврогийн урт хугацаат зээлийн эргэн төлөлт 11.4 сая евро буюу 30,180.4 сая төгрөг, зээлийн үлдэгдэл 75.1 сая евро буюу 241,907.9 сая төгрөг байна.

"Турбоагрегат 1,2,3,4-ийг шинэчлэх" зээлийн тайлант хугацаанд ногдох, төлөгдөөгүй үндсэн зээлийн төлбөр 7.3 сая евро буюу 23,502.1 сая төгрөг, үндсэн хүүгийн төлбөр 1.7 сая евро буюу 5,540.6 сая төгрөг, торгуулийн хүү 41.2 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Хөгжлийн банкнаас авсан зээл төлөгдөхгүй байгаа нь Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Эрчим хүчний сайдын тушаалаар баталсан "Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам"-ын 1.3-т "Эрчим хүчний зохицуулах хороо болон аймаг нийслэлийн зохицуулах зөвлөл энэ журам хэрэгжих хугацаанд хэрэглэгчийн тарифт өөрчлөлт оруулахгүй" гэж заасны дагуу үнэ тарифыг нэмэгдүүлээгүй, тариф батлахдаа 2021 оны цахилгаан эрчим хүчний дундаж тарифыг 60.9 төг/квтц-аар тооцож 2020 оны батлагдсан тарифаас 8.6 төг/квтц-аар бууруулснаар компани мөнгөн хөрөнгийн дутагдалд орж зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлж чадахгүйд хүрсэн байна. Зээлээ хугацаандаа төлөөгүйгээс хүү, алданги нэмэгдэж, цаашлаад компанийн төлбөрийн чадвар буурч, санхүүгийн хүндрэлд орж болзошгүй үр дагавартай байна.

Шалгагдагч компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлыг эдийн засгийн үр ашгийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлж байгаа бөгөөд хэмжиж болохуйц байвал хүлээн зөвшөөрнө, төлсөн, эсвэл төлөхөөр хүлээгдэж байгаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнээр хэмжинэ гэж заасан байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад 648.9 сая төгрөгөөр буурсан ч гадаад валютын ханшийн зөрүүний нөлөөг хасвал өмнөх оноос 35,229.8 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь боловсруулсан цахилгаан эрчим хүчний хэмжээ өмнөх онтой харьцуулахад 10.4 хувиар, үйлдвэрлэсэн дулааны эрчим хүчний хэмжээ 3.5 хувиар өссөнтэй холбоотойгоор зарцуулсан түлш, материалын зардал, цалингийн зардал, үйлдвэрийн ашиглалтын зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэхтэй холбоотой шууд материалын зардал буюу зарцуулсан түлш, түүхий эд материалын зардал, шууд хөдөлмөрийн зардал болох цалингийн зардал болон ашиглалтын зардал, элэгдлийн зардал, зээлийн хүүгийн зардал, хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал, зохицуулалтын үйлчилгээний зардал зэрэг зардлуудыг хамруулсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны 9 дүгээр тушаалаар Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 280,782.7 сая

төгрөгөөр, нийт зардлыг 297,369.8 сая төгрөгөөр, 16,587.1 сая төгрөгийн алдагдал байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 26,578.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Эрчим хүчний сайдын 2021 оны 196 дугаар тушаалаар их завсар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 935.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 348,222.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 329,207.7 сая төгрөгийн зардал гарган, 17,829.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 348,222.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 67,439.4 сая төгрөг буюу 24.0 хувиар өссөн дүнгээс гадаад валютын ханшийн бодит бус орлого 32,409.0 сая төгрөгийг хасаж тооцвол нийт орлого 35,030.4 сая төгрөгөөр давсан байна. Үүнд ЦЭХ-ний орлого 18,578.6 сая, ДЭХ-ний орлого 2,785.6 сая төгрөгөөр өссөн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 329,207.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 31,837.9 сая төгрөг буюу 11.0 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайлант оны үйлдвэрлэлийн хэмжээ өссөнтэй холбоотойгоор шууд материал болох түлшний зардал төлөвлөснөөс 12,154.2 сая төгрөг буюу 8.0 хувиар, цахилгаан эрчим хүч, дулааны эрчим хүч зэрэг ашиглалтын зардлууд нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Мөн тайлант онд "Турбоагрегат №3"-ыг ашиглалтад оруулсантай холбоотойгоор элэгдлийн зардал төсөвлөснөөс 11,038.8 сая төгрөгөөр буюу 21.0 хувиар хэтэрсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 167 ажилд өөрийн эх үүсвэрээс 21,115.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 17,829.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 34,416.9 сая төгрөгөөр илүү байгаа нь үйл ажиллагааны бус орлого болох гадаад валютын ханшийн зөрүүний олз нөлөөлсөн байна.

ТӨБЗГ-т түрээсийн орлогын 40.0 хувь буюу 71.9 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь тайлант онд нийт 1,181,274.7 сая төгрөгийн 3569 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 7,831.2 сая төгрөгийн 85 мэдээллийг хугацаа хоцроож, 73.0 сая төгрөгийн бараа материал нийлүүлэх гэрээний үнийн дүнг 40.0 сая төгрөг, тендэрт шалгарсан Түмэн төмөрт ХХК-ийн нэрийг Ав Шүтээн гэж тус тус буруу мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр

зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;" 4.1.3-г "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 10.1.11-д заасныг тус тус үндэслэн төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг харгалзан Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолыг гаргасан.

Аудитаар тус тогтоолд заасан зардлуудыг хэмнэсэн, тухайн зардлуудыг гаргасан эсэхийг шалгалаа.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь тайлант онд хамтын гэрээнд заасны дагуу байгууллагын ажилтан, тэтгэвэрт гарсан ахмад настнууд, бусад байгууллагын ажилтан албан хаагчдад 548.8 сая төгрөгийн шагнал, урамшуулал олгосон, спортын уралдаан тэмцээн, байгууллагын хөдөлмөрийн аварга шалгаруулах арга хэмжээ, ахмадуудын чөлөөт ярилцлага зохион байгуулсан зэрэг зардалд 13.7 сая төгрөг зарцуулсан, телевизээр мэндчилгээ дэвшүүлэх болон баримтат нэвтрүүлэг хийлгэх зардалд 16.4 төгрөг зарцуулсан, 1.4 сая төгрөгийн үнэ бүхий бэлэг дурсгалын зүйлс, 16.4 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 20.5 сая төгрөгийн Спорт хувцас, хэрэгсэл худалдан авсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3-д "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, тайлант хугацаанд гаргасан зарим зардал нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 346,742.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 23.3 сая төгрөгийг залруулж, 346,584.0 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 135.1 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,859.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 45.2 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгснөөс албан шаардлагын хэрэгжилт 50.0 хувь, зөвлөмж 60.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

/мянган төгрөг/

Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	2	6,859,013.0	1	6,604,064.5	1	254,948.5	50.0
Зөвлөмж	5	45,226.3	3	-	2	45,226.3	60.0
Нийт дүн	7	6,904,239.3	4	6,604,064.5	3	300,174.8	55.0

Өмнөх оны аудитаар өгсөн бараа ажил үйлчилгээ худалдан авах тендерийн шалгаруулалтад тендерийн бичиг баримтын зөрчилтэй компанийг шалгаруулсан, авлагын үлдэгдлыг тулган баталгаажуулаагүй, тендерийн бичиг баримтын бүрдэл дутуу зэрэг алдаа, зөрчил давтан гарсан асуудалд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хойшлогдсон татварын өр төлбөр үүсгэж байгаа үндсэн хөрөнгийн ашиглалтын жилээс үүссэн зөрүү болон 12 дугаар сард баталсан ЗГ-ын 2021 оны 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг дараагийн аудитаар шалгах нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,300.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5,196.2 сая төгрөгийн 13 алдааг залруулж, 16.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 82.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 5.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 104.1 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 2,866.6 сая төгрөгийн түвшнээс 2,762.5 сая төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 5,196.2 сая төгрөгийн 13 алдааг залрууллаа. Үүнд:

- Даатгалын гэрээтэй холбоотой дараа оны 9.4 сая төгрөгийн даатгалын зардлыг тайлант оны зардлаар бүртгэсэн;
- НББОУС-1-ийн 87 дугаар зүйлтэй нийцээгүй, үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 1,443.9 сая төгрөгийг өмнөх үеийн хуримтлагдсан ашиг дансанд бүртгэсэн нь, үнэлгээ ба хуваарилалт, ангилал батламж мэдэгдлүүдийг хангаагүй;
- НББОУС-16-ийн 41 дүгээр зүйлтэй нийцээгүй, дахин үнэлгээ хийгдсэн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахдаа дахин үнэлгээний нэмэгдлийг 2.9 сая төгрөгөөр зөрүүтэй хассан;
- НББОУС-1-ийн 69 дүгээр зүйлтэй нийцээгүй, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн 1-ээс дээш жилийн хугацаанд хамаарах 750.8 сая төгрөгийн орлогыг урьдчилж авсан орлого дансанд бүртгэсэн;
- НББОУС-20-ийн 15 дугаар зүйлтэй нийцээгүй орлогын аргаар бүртгэсэн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгүүдийн тайлант оны элэгдлийн зардалд ногдох бусад орлогыг 22.3 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн;
- НББОУС-1-ийн 69 дүгээр зүйлтэй нийцээгүй, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгүүдийн дараа онд хэрэгжих 928.8 сая төгрөгийн орлогыг хойшлогдсон орлогоос урьдчилж орсон орлого руу ангилж бүртгээгүй;
- НББОУС-1-ийн 66 дугаар, НББОУС-7-ын 6 дугаар зүйлүүдтэй нийцээгүй, замд яваа 1,170.2 сая төгрөгөөр харилцагчид өгөх өглөг, НДШ-ийн өглөгийн үлдэгдлийг бууруулж бүртгэсэн;
- НББОУС-1-ийн 69 дүгээр зүйлтэй нийцээгүй, төлбөр нь урьдчилан төлөгдсөн 76.4 сая төгрөгийн бараа материалын орлогыг бүртгэхдээ төлөгдсөн дүнгээр дансны өглөг давхар үүсгэн бүртгэсэн;

- НББОУС-1-ийн 69 дүгээр зүйл, Санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлалын 4.46 дүгээр зүйлтэй нийцээгүй, зээлийн хүүгийн зардлыг 118.3 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн өглөгийг 116.4 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн төлөлтийг 83.4 сая төгрөгөөр тус тус дутуу бүртгэсэн;
- НББОУС-21-ийн 28-29 дүгээр зүйлтэй нийцээгүй, Сангийн Яамнаас авсан зээлийн үлдэгдэлтэй холбоотойгоор гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит гарзыг 7.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн;
- НББОУС-21-ийн 28-29 дүгээр зүйлтэй нийцээгүй, зээлийн хүүгийн төлөлттэй холбоотой 28.4 сая төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит олзыг гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус олзоор бүртгэсэн;
- НББОУС-21-ийн 28-29 дүгээр зүйлтэй нийцээгүй, зээлийн хүүгийн өглөгийн бүртгэлтэй холбоотойгоор гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус олзыг 74.7 сая төгрөгөөр, гадаад валютын ханшийн бодит бус гарзыг 131.6 сая төгрөгөөр тус тус илүү бүртгэсэн;
- НББОУС-12-ын 15-16 зүйлүүдтэй нийцээгүй, гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус олзноос үүсэх 231.2 сая төгрөгийн хойшлогдсон татварын өр төлбөрийг бүртгээгүй.

8.2 Төлбөрийн акт

Сахилгын шийтгэл оногдуулсан ажилтанд 0.7 сая төгрөгийн үр дүн, 15 ажилтанд 15.4 сая төгрөгийн цалин илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," 20.2.4-д "Нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах," гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Акт тогтоох

8.3 Албан шаардлага

Алхан бутлагчийн алх, брус нийлүүлэх 135.0 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах тендерийн шалгаруулалтад тендерийн бичиг баримтын зөрчилтэй компанийг шалгаруулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д "Энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага," болон 16.2-т "Энэ хуулийн 16.1-д заасан баримт бичгээс тухайн тендер шалгаруулалтад ирүүлэх шаардлагатай баримт бичиг, тэдгээрт тавигдах шаардлагыг тендерийн баримт бичигт заана," гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Тендерийн бичиг баримтаас түүвэрлэн шалгахад хурлын тэмдэглэлийн он сарыг зөрүүтэй оруулсан, үнэлгээний хорооны тэмдэглэл байхгүй, үнэлгээний хорооны гишүүд хуралдсан тэмдэглэл гарын үсгээр баталгаажуулаагүй, цахим тендерийн урилга болон цаасаарх урилга хоёрын тендер нээх хугацаа зөрүүтэй, тендерийн нээлтийн тэмдэглэлд зарим гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, үнэлгээний хорооны гишүүдийн оролцогчдыг үнэлсэн маягтын үзүүлэлтүүдийн үнэлгээ зөрүүтэй, гэрээ байгуулах тухай мэдэгдсэн албан бичиг байхгүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т заасан баримт бичгийн бүрдлийг ханган ажиллаагүй, 47 дугаар зүйлийн 47.8-д "бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Авлагын дансыг гуравдагч талтай тулган баталгаажуулах захидал илгээхэд 6 байгууллагын 61.2 сая төгрөгийн тулган баталгаажуулах захидлын хариу ирээгүй байна. Энэ нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Батлагдаагүй ирцийн бүртгэлээр 21.4 сая төгрөгийн илүү цагийн цалин бодож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." , 13.5-д "анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна."13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно;" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нийгмийн даатгалын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын тайланд 34.7 сая төгрөгийн ХЧТА-ы тэтгэмжийг цалингийн бүрэлдэхүүнд оруулж илүү тайлагнаж, 5.4 сая төгрөгийн НДШ-ийн зардал илүү бүртгэсэн байна. Энэ Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн "Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ХЧТА-ы тэтгэмжээс татвар, нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	/мянган төгрөгөөр/											
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Даатгалын гэрээтэй холбоотой дараа оны даатгалын зардлыг тайлант оны зардлаар бүртгэсэн.	Залруулав	1	9,316.6	1	9,316.6								
2	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзыг өмнөх үеийн хуримтлагдсан ашиг дансанд бүртгэсэн.	Залруулав	1	1,443,905.7	1	1,443,905.7								
3	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Дахин үнэлгээ хийгдсэн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахдаа дахин үнэлгээний нэмэгдлийг зөрүүтэй хассан.	Залруулав	1	2,892.8	1	2,892.8								
4	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн 1-ээс дээш жилийн хугацаанд хамаарах урьдчилж авсан орлого дансанд бүртгэсэн.	Залруулав	1	750,820.0	1	750,820.0								
5	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгүүдийн дараа онд хэрэгжих орлогыг хойшлогдсон орлогоос урьдчилж орсон орлого руу ангилж бүртгээгүй.	Залруулав	1	928,840.6	1	928,840.6								
6	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Замд яваа мөнгийг харилцагчид өгөх өглөг, НДШ-ийн өглөгийн үлдэгдлийг бууруулж бүртгэсэн.	Залруулав	1	1,170,169.1	1	1,170,169.1								
7	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Төлбөр нь урьдчилан төлөгдсөн бараа материалын орлогыг бүртгэхдээ төлөгдсөн дүнгээр дансны өглөг давхар үүсгэн бүртгэсэн.	Залруулав	1	76,371.7	1	76,371.7								

8	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Зээлийн хүүгийн зардал, зээлийн хүүгийн өглөг, зээлийн хүүгийн төлөлтийг тус тус дутуу бүртгэсэн.	Залруулав	1	318,149.0	1	318,149.0										
9	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Сангийн Яамнаас авсан зээлийн үлдэгдэлтэй холбоотойгоор гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит гарзыг дутуу бүртгэсэн.	Залруулав	1	7,501.8	1	7,501.8										
10	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Зээлийн хүүгийн төлөлттэй холбоотой гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит олзыг гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус олзоор бүртгэсэн.	Залруулав	1	28,411.9	1	28,411.9										
11	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Зээлийн хүүгийн өглөгийн бүртгэлтэй холбоотойгоор гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус олз, гадаад валютын ханшийн бодит бус гарзыг тус тус илүү бүртгэсэн.	Залруулав	1	206,309.8	1	206,309.8										
12	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус олсноос үүсэх хойшлогдсон татварын өр төлбөрийг бүртгээгүй.	Залруулав	1	231,222.2	1	231,222.2										
13	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Орлогын аргаар бүртгэсэн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгүүдийн тайлант оны элэгдлийн зардалд ногдох бусад орлогыг 22.3 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн	Залруулав	1	22,311.1	1	22,311.1										
14	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Сахилгын шийтгэл оногдуулсан ажилтанд 0.7 сая төгрөгийн үр дүн олгосон, 15 ажилтанд 15.4 сая төгрөгийн цалин илүү олгосон байна.	Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов	1	16,133.3			1	16,133.3								
15	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Авлагын дансыг гуравдагч талтай тулган баталгаажуулах захидал илгээхэд 6 байгууллагын 61.2 сая төгрөгийн тулган баталгаажуулах захидлын хариу ирээгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангах	1	61,163.5					1	61,163.5						

01
 ТӨХК-ийн Аудитын Байгууллага
 ЗӨРЛӨГӨӨ
 САЛГАГЧИЙН ТӨХК

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

16	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Батлагдаагүй ирцийн бүртгэлээр 21.4 сая төгрөгийн илүү цагийн цалин бодож олгосон байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангах	1	21,395.9							1	21,395.9				
17	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Нийгмийн даатгалын тайланд 34.7 сая төгрөгийн ХЧТА-ын тэтгэмжийг цалингийн бүрэлдэхүүнд оруулж илүү тайлагнасан байна. Дээрх тайлагналтай холбоотойгоор 5.4 сая төгрөгийн НДШ-ийн зардал илүү бүртгэсэн байна.	ХЧТА-ы тэтгэмжээс татвар, нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахгүй байх.	1	5,385.0											1	5,385.0
ДҮН					17	5,300,299.8	13	5,196,222.1	1	16,133.3	2	82,559.4			1	5,385.0		
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																		
1	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Хамтын гэрээнд заасны дагуу байгууллагын ажилтан, тэтгэвэрт гарсан ахмад настууд, бусад байгууллагын ажилтан албан хаагчдад 548.8 сая төгрөгийн шагнал, урамшуулал олгосон, спортын уралдаан тэмцээн, байгууллагын хөдөлмөрийн аварга шалгаруулах арга хэмжээ, ахмадуудын чөлөөт ярилцлага зохион байгуулсан зэрэг зардалд 13.7 сая төгрөг зарцуулсан, телевизээр мэндчилгээ дэвшүүлэх болон баримтат нэвтрүүлэг хийлгэх зардалд 16.4 төгрөг зарцуулсан, 1.4 сая төгрөгийн үнэ бүхий бэлэг дурсгалын зүйлс, 16.4 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 20.5 сая төгрөгийн Спорт хувцас, хэрэгсэл худалдан авсан байна.	Компанийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах	1	617,163.5								1	617,163.5			
2	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Алхан бутлагчийн алх, брус нийлүүлэх 135.0 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах тендерийн шалгаруулалтад тендерийн бичиг баримтын	Өмнөх оны аудитаар хүргүүлсэн тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн баримт бичигт заасны дагуу үнэлэх албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй	1	135,055.8								1	135,055.8			

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			зөрчилтэй компанийг шалгаруулсан байна.	Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга В.Лхагвадоржид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах																
3	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Төндөрийн бичиг баримтаас түүвэрлэн шалгахад хурлын тэмдэглэлийн он сарыг зөрүүтэй оруулсан, үнэлгээний хорооны тэмдэглэл байхгүй, үнэлгээний хорооны гишүүд хуралдсан тэмдэглэл гарын үсгээр баталгаажаагүй, цахим төндөрийн урилга болон цагаарх урилга хоёрын төндөр нэх хугацаа зөрүүтэй, төндөрийн нээлтэй тэмдэглэл зарим гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, үнэлгээний хорооны гишүүдийн оролцогчдыг үнэлсэн маягтын үзүүлэлтүүдийн үнэлгээ зөрүүтэй, гараа байгуулах тухай мэдэгдсэн албан бичиг байхгүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн зөрчлөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төндөрийн баримт бичгийн бүрдлийг хангах	1	-				1	-									
4	Дулааны IV цахилгаан станц ТӨХК	АХГ-2022/95/НА-СТА-ТӨА	Худалдан авах ажиллагааны тайланг шилэн дансны цахим системд мэдээлэхэд буруу мэдээлэл оруулсан байна.	Өмнөх оны аудитаар хургуулсан шилэн дансны мэдээллийг үнэн зөв, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэх албан шавардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй Шилэн данс харуусан албан тушаалтад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах	1	-													1	-
			ДҮН		4	752,219.3				3	752,219.3								1	-
			НИЙТ ДҮН		21	6,062,619.1	13	5,196,222.1	1	16,133.3	6	834,778.7							2	5,385.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 524/А0150055

Улаанбаатар хот

АХТ-2022/95/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь хамтын гэрээнд заасны дагуу байгууллагын ажилтан, тэтгэвэрт гарсан ахмад настнууд, бусад байгууллагын ажилтан, албан хаагчдад 548,711,813.00 төгрөгийн шагнал, урамшуулал олгосон, спортын уралдаан тэмцээн, байгууллагын хөдөлмөрийн аварга шалгаруулах арга хэмжээ, ахмадуудын чөлөөт ярилцлага зохион байгуулсан зэрэг зардалд 13,723,478.79 төгрөг зарцуулсан, телевизээр мэндчилгээ дэвшүүлэх болон баримтат нэвтрүүлэг хийлгэх зардалд 16,418,181.82 төгрөг зарцуулсан, 1,400,000.00 төгрөгийн үнэ бүхий бэлэг дурсгалын зүйлс, 16,445,000.00 төгрөгийн тавилга, эд хогшил, 20,465,000.00 төгрөгийн Спорт хувцас, хэрэгсэл худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 "Төсвийн хэрэгжилтэд хяналт тавих", 10.1.11 "Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", 1.4 "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх", 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх," гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даван

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

\\s1010120\backlog_khang\2022\202211\Auditin 7 Gоор-190.Docx

0001081367


гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгав.

АЛБАН ШААРДАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
У.ОЮУНАА

МОНГОЛ
УЛСЫН АУДИТОРЫН
ГАЗАР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 525/АО 150055
АУГ-2022/95/НА-СТА-ТВА
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн Авлагын дансыг гуравдагч талаар тулган баталгаажуулахад 61,163,505.67 төгрөгийн тулган баталгаажуулах захидлын хариу ирээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



0001081370



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 526/АО150055

Улаанбаатар хот

АХГ-2022/95/НА - СТА - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн зарим тендерийн бичиг баримтад хурлын тэмдэглэлийн он, сарыг зөрүүтэй оруулсан, үнэлгээний хорооны тэмдэглэл байхгүй, үнэлгээний хорооны гишүүд хуралдсан тэмдэглэл гарын үсгээр баталгаажуулаагүй, цахим тендерийн урилга болон цаасаарх урилга хоёрын тендер нээх хугацаа зөрүүтэй, тендерийн нээлтийн тэмдэглэлд зарим гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, үнэлгээний хорооны гишүүдийн оролцогчдыг үнэлсэн маягтын үзүүлэлтүүдийн үнэлгээ зөрүүтэй, гэрээ байгуулах тухай мэдэгдсэн албан бичиг байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.8 "Бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна;" 49 дүгээр зүйлийн 49.2 "Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ;" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тендерийн баримт бичгийн бүрдлийг хангаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртогоо нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
 АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
 ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
 ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
 Ц.ХОСЖАРГАЛ
 У.ОЮУНАА



Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Баян Монгол-2, Хэвгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

510 10 10 20/Монгол_Хэрэг/Албан_Шаардлага/2022/01/11 Аудитын Газар-181.1.docx





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 527/А0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/95/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь Батлагдаагүй ирцийн бүртгэлээр 21,395,912.01 төгрөгийн илүү цагийн цалин бодож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна," 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна," 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно," гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт даалгаа.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

У.ОЮУНАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 15 № 529/АО150055
АХГ-2022/95/НА-СТА-ТБА

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь өмнөх аудитаар хүргүүлсэн худалдан авах ажиллагааны шалгаруулалтыг тендерийн баримт бичигт заасны дагуу шалгаруулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд алхан бутлагчийн алх, брус нийлүүлэх 135,055,800.00 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийн шалгаруулалтад тендерийн баримт бичгийн зөрчилтэй компанийг шалгаруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 "Энэ хуулийн 16.1-т заасан баримт бичгээс тухайн тендер шалгаруулалтад ирүүлэх шаардлагатай баримт бичиг, тэдгээрт тавигдах шаардлагыг тендерийн баримт бичигт заасан баримтын шаардлагыг хангаж ажиллах", 27 дугаар зүйлийн 27.1.1 "Энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага", 47 дугаар зүйлийн 47.2 "Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна", 47.2.2 "тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх" гэнэ заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад харуу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх оны аудитаар хүргүүлсэн тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн баримт бичигт заасны дагуу үнэлэх албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга В.Лхагвадоржид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуягт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

(Handwritten signatures and stamps)

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
У.ӨЮУНАА

01 0001081364



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 533/А0150055
АХГ-2022/95/НА-СТА-70А

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь өмнөх аудитаар шилэн дансны мэдээллийг үнэн зөв, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 3569 мэдээллээс 85 мэдээллийг хугацаа хоцроож, 73,319,072.00 төгрөгийн бараа материал нийлүүлэх гэрээний үнийн дүнг 39,980,629.00 төгрөг, тендэрт шалгарсан Түмэн төмөрт ХХК-ийн нэрийг Ав Шүтээн гэж тус тус буруу мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдээдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар хүргүүлсэн шилэн дансны мэдээллийг үнэн зөв, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэх албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй Шилэн данс хариуцсан албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуягт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
 АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
 ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
 Ц.ХОСЖАРГАЛ
 Ү.ОЮУНАА

0001081366



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 123/А0150055
АКТ-2022/95/НД - СТА - ТВА
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь Сахилгын шийтгэл оногдуулсан ажилтанд 761,778.95 төгрөгийн үр дүн, 15 ажилтанд 15,371,515.00 төгрөгийн цалинг тус тус илүү олгосон байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4 "Нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах," гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нэр бүхий ажилтнуудад олгосон илүү олгосон 16,133,293.95 (арван зургаан сая нэг зуун гучин гурван мянга хоёр зуун ерэн гурван төгрөг ерэн тав) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000501 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртоогоо нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
У.ОЮУНАА



Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс